

**“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2015 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 7 дугаар
сарын 1-ний өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн А.Бакей**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдээ,

“Монгол Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулж, 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хороо хуулийн төсөл санаачлагчдаас урьдчилан санал авахад Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 17, Байнгын хороодоос 37, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдээс 42, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ц.Даваасүрэн С.Оюун нараас 11, Монгол Улсын Засгийн газраас 39, нийт 146 төслийг хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгуулахаар санал ирүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай тогтоолын төслийг боловсруулахдаа:

-Намрын чуулганаар хэлэлцэн батлахаар хуульд тусгайлан заасан хууль, тогтоолын төслүүд;

-Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатанд байгаа төслүүдээс холбогдох Байнгын хороод нь эхний ээлжинд хэлэлцүүлэхээр санал болгосон төслүүдийг багтаах гэсэн зарчмыг баримтлан тогтоолын төсөлд 24 төслийг нэр заан тусгалаа.

Байнгын хорооны хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл Монгол Улсын хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тогтоолын төсөлд нэмэх санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжлээ.

Тогтоолд зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төслийг ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулахдаа Байнгын хороодын саналыг харгалзах нь зүйтэй гэж үзлээ.

Түүнчлэн одоогоор боловсруулах шатандаа байгаа, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдээгүй бусад төслүүдийг өргөн мэдүүлсэн үед нь хэлэлцүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлэж байх нь зүйтэй байна.


Тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

“Монгол Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



А.БАКЕЙ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот**Улсын Их Хурлын 2015 оны намрын
ээлжит чуулганаар хэлэлцэх
асуудлын тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулийн төсөл;

2/Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хуулийн төсөл;

3/Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуулийн төсөл;

4/“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

5/Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

6/Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай болон холбогдох бусад хуулийн төсөл;

7/Худалдааны тухай болон холбогдох бусад хуулийн төсөл;

8/Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

9/Хөрөнгийн албан татварын тухай болон холбогдох бусад хуулийн төсөл;

10/Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;

11/Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

12/Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

13/Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүд;

14/Хүүхэд хамгааллын тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд;

15/Хүүхдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүд;

16/“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, “Халх гол чөлөөт бүс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

17/Органик хүнсний тухай хуулийн төсөл;

18/Хог хаягдлын тухай хуулийн төсөл;

19/Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

20/Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

21/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүд;

22/Прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

23/Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

24/Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

25/бусад.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Монгол Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг болон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Болдбаатар/-т тус тус үүрэг болгосугай

Гарын үсэг